

ТАНДЭМ ИНВЭСТ ББСБ ХК-ИЙН 2024 ОНЫ 10 САРЫН 19-НИЙ ӨДРИЙН
ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТООЛЛОГЫН
КОМИССЫН ШИЙДВЭР

2024 оны 10 сарын 19 өдөр

Дугаар 01

Улаанбаатар хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын
ирц, санал хураалтын дүнг танилцуулах тухай:*


Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны 10 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын ирц Компанийн гаргасан саналын эрхтэй нийт хувьцаа буюу 2,000,000,000 ширхэг энгийн хувьцаанаас тус өдрийн хуралд 1,005,223,719 ширхэг энгийн хувьцаа эзэмшигчид ирсэн нь саналын эрх бүхий хувьцааны 50.26% болж ирц бүрдсэн байна. Энэ нь хурлын ирц Компанийн тухай хуулийн 69-р зүйлийн 69.1-д заасан болон Компанийн дүрэмд заасантай тус тус бүрэн нийцсэн.


1. Компанийг нэгтгэх асуудалд хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26% саналаар татгалзсан саналтай байна.
2. Компанийг нэгтгэх асуудалтай холбогдуулан Хувьцааг тэргүүн ээлжид худалдан авах эрхийг хэрэгжүүлэх тухай асуудалд хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26% саналаар татгалзсан саналтай байна.
3. Компанийг нэгтгэх асуудалтай холбогдуулан Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх эсэх тухай асуудалд хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26% саналаар татгалзсан саналтай байна.
4. Компанийн шинэчилсэн дүрмийн өөрчлөлтүүдийг хуралд ирсэн саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 98.8% саналаар, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн 50.26% саналаар татгалзсан саналтай байна.

Тандэм Инвэст ББСБ ХК-ийн 2024 оны 10 сарын 19-ний өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар дээрх асуудлыг хэлэлцэж саналыг саналын хуудсаар авч баталгаажууллаа. Хуралд нийт 4 хувьцаа эзэмшигчдээс саналын хуудас ирсэн бөгөөд 4 саналын хуудсыг хүчинтэйд тооцсон.

Хуулбарыг Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ид холбогдох материалын хамт хүргүүлэхийг Гүйцэтгэх захирал Б.Бадамцэцэгт үүрэг болгосугай.

ТООЛЛОГЫН КОМИССЫН ДАРГА  М.УЯНГА

ТООЛЛОГЫН КОМИССЫН ГИШҮҮД  В.ШИНЭБАЯР

 Т.БАТЧИМЭГ

